



Соёл эрдэм

ᠰᠣᠶ᠋ᠣᠯ ᠡᠷᠳᠡᠮ ᠤᠯᠤᠰ

モンゴル文化教育大学

Хэлтэй бол хөлтэй

2006 он

9-р сар

№02

ХИЧЭЭЛИЙН

ШИНЭ ЖИЛ ЭХЭЛЛЭЭ



Мэндийлээ

2007-2008 оны хичээлийн шинэ жил эхэлж эхэлсэн болон нийт оюутан залуутай сурлагын өндөр амжилт хүснэ. Тэр бүхэн хичээлээр ялан хэл соёлын эрдэмтэй эргэлтээр хүрч чадна. Боловсролын бичигтэй байх нь манайт бичиг, ажилдаах улам шийдлийг бүтээж урам зориг эрх хүчээр дүүрэн байхыг хүснэ. Сая "Соёл эрдэм" их сургуульд элсэхээр 23 оюутан эрхэлдэггүйс оюун ухаан, мэдлэг чадваруараа шалгарч танисан өөрсдэд оюутандаа баар курс. Тэд маань Монголын соёлыг Японд таниуулах үүснэгтэд нэвдэрт мандуулан амжилттай сурвал ирэхийг хүссээс хүсч байна.

"Соёл эрдэм" дээд сургууль нь аливаа хайрлах, хүмүүст итгэх сэтгэлгээгээр төлөвшин нийгмийн идэвх бүхий өндөр үрэг хариуцагатай ирсэн, эх орон эрд түмнийхээ төлөө цаашийг ил эрүүл бүтээх чадал бүхий тийм боловсон хүчнийг бэлтгэн гаргадаг сургалтын байгууллага байхыг илэст эргэлтэй болно.



"Соёл эрдэм" дээд сургуулийн ерөнхий захирал Махихара Соичи

Шинэ байр удахгүй ашиглалтад орно

"Соёл эрдэм" дээд сургуулийн өргөтгөл таван дөхөр саарал байшинг барихаар одоогоос хоёр жилийн өмнө зураг төсөл нь хийгдэж оюутнуудын сэтгэлийг хөөрвөд амжсан. Хүсн хүлээсэн сургуулийн шинэ байр саяхнаас сууриа тавьж барилгын ажил хэдийн эхэлжээ. Сургуулийн орлогч захирал Р.Батжаргалтай уулзаж энэ талаар тооч мэдээлэл авлаа.

-Аравдугаар сар гараад хүйтэрхээр барилгын ажил зогионо гэж сонссон. Өнөө жилдээ багтаж ашиглалтад орох уу?

-Энэ сард дулааны шугамын ажлаа хийгээд барилгын ажил цаашир хэвийн үргэлжлэх болно. Хагас семестрээ багтаад барилгын ажлыг бүрэн дуусгах төлөвлөгөөтэй байгаа. Барилга баригдаж эхлэх эвчлөлийг 2006 оны наймдугаар сарын 11-нд авсан.

-Шинэ барилга сургуулийн самбарт гарсан зурагтай адилхан баригдах уу. Зурган дээрээс үзвэл их гоё барилга юм билээ?

-Тиймээ. Анхны гарсан зургийн дагуу баригдана.

-Шинэ байранд хэд дүгээр курсын оюутнуудыг хичээллүүлэх вэ?

-Заавал тэддүгээр курсын оюутнуудыг шинэ өмнөгийн байранд оруулна гэж юм байхгүй дээ. Одоогоор сургуулийн байрны хүчин чадалаас шалтгаалан "Алтай" дээр сургууль дээр энэ тэрэгсэн 4-р курсын оюутнууд хичээллэх гэж байгаа. Шинэ байранд бүх оюутнууд орсон ч багтана л даа. (инээ)

Олон улсын сэтгүүлчийн Эс энгийн оюутан Т.Гэрэлчигал

Буян хийдэг сайхан сэтгэлтэй Япон хүч



Оно Шигэ бол Япон улсын хүүхэд залуучуудын боловсролын төв "Харими Центр"-ийн ерөнхийлөгч. Монголд эхэлтэй Япон хүний нэг энэ хүн Төв аймгийн 27 сумын сургуулиаас төгссөдсөн эрвэр төрүү мөхсөн хүүхэд 1993-2003 он хүртэл 10 жилийн туршидтай буцаагүй туслалжаар бичигт үсэг таниуулах айсан бус сургалт явуулсан бүхтэй хүн. 2003 онд Төв аймгийн Бирон суманд амжилттай багаста эрмэлээр Зөгийний үлдээр байуулсан. Одоо тэнд олон хүн ажил амьдралаа залуугийн тэр бүр амжилтадтай байсан ажилны ноороо үйлдвэрлэлд нийлүүлж байна. Тэрээр түр аймгийн хүүхэд өргөн БСШУ-ны яамны хүүхэд эрүү Бичигэр шалгуулсан. Мөн 2002 онд Монголд ийсэн оюунч явдалмөрийн нь төр зогсоос уналд Япон-Монголын дипломат харилцаа тогтоосон 30 жилийн өдөр хүрээнд ерөнхийлөгч Н.Багабандиар Олон улсын Эрдэмтдийн найрамдлын мөхлөгөөр шалгууриг байсан. Оно Шигэ Монголын боловсролын салбарт тулганасан асуудалд хамгийн үр дүртэй гэрээ суналт тусалд Монголын үр хүүхэд эхэлтэй мөхлөг сэтгэлээр хандсангад олон мянган мөхлөгүүд талархдаг билээ.



Оно Шигэ "Шигэгийн Буян" хүүхдийн бичигт оюутнуудтай хамт, 2002. 7-р сар

Оно Шигэ Харими Центр-ийн ажилтан хамт, 2002. 7-р сар

ШИНЭ ОЮУТНЫ СЭТГЭГДЭЛ

ТӨГСӨГЧДӨӨ ЯПОН ЯВУУЛДАГ НЬ
ИХ ТААЛАГДСАН

-Өөрийгөө товч танилцуулна уу?

-Намайг Нямдаваа гэдэг. Одоо 17 настай. Нийслэлийн 23-р дунд сургуулийг төгссөн. Энэ жил компьютерийн 1е ангид элсэн орсон.

-Энэ сургуулийг яагаад сонгох болов?

-Манай эгч надад анх санал болгосон. Япон хэлийг туршлага-

тай сайн багш нар заадаг. Тэгээд ч төгсөөд ихэнх оюутнууд нь Япон явдаг нь маш сайхан санагдсан.

-Ер нь япон хэл бусад хэлнээс юугаараа давуу талтай гэж боддог вэ?

-Япон хэлний өгүүлбэрийн бүтэц нь Монгол хэлтэй адилхан байдаг болохоор

сурахад дөхөм байдаг. Мөн дурс үсэг буюу ханз нь тухайн зүйлээ бараг дүрслэн үзүүлсэн байдаг учраас цээжлэхэд амар хялбар гэж боддог.

-Энэ сургуульд орсон сэтгэгдлээсээ хуваалцаач?

-Багш нар төдийгүй сургуулийн захирал маань ч оюутан

болгонтой тулж ажиллаж, их анхаарал тавьдаг юм билээ. Дээд ангийн болон төгсөгч ах эгч нарыг харахад эргээд сургуультайгаа ямар нэгэн байдлаар байнга холбоотой байдаг нь үүнтэй холбоотой гэж бодож байна. Манай сургууль жуулчны баазтай гэж сонссон. Зунхаа

амралтаар оюутнууд тэнд ажиллаж хэлнийгээ мэдлэгийг дээшлүүлдэг нь сайхан боломж. Дараа жилийн зунхаа амралтаар явахаар төлөвлөж байгаа.

Олон улсын сэтгүүлчийн 3с ангийн оюутан Т.Гэрэлчимэг

Сургалтын төлбөрөөс
чөлөөлөгдөж хэлний мэдлэгээ
дээшлүүлсэндээ баяртай байна

"Соёл Эрдэм" сургуулийн харьяа "Шилийн бүлэг" жуулчны баазад зунхаа амралтаар олон оюутан ажиллаж, сургалтын төлбөрөөсөө зохих хувиар чөлөөлөгддөг. Өнгөрсөн зун 20 гаруй оюутан жуулчны баазад ажиллаж нийт 4 сая гаруй төгрөгийн хөнгөлөлттэй болжээ. Тэдний нэг Олон улсын сэтгүүлчийн IY курсийн оюутан Б.Бат-Эрдэмтэй уулзаж ярилцлаа.

-Өнгөрсөн зун нийт хичээл оюутан ажиллав?

-Энэ зун 20 гаруй оюутан тэнд ажилласан. Бидэнд хийх ажил захиасаа аваад мундахгүй олон. Түлээ мод хагалахаас эхлээд жуулчдын гэрт гал түлэх, хоол үнд хийх, Жуулчид өглөөний цайгаа уучихаад гараад ирэхэд унах мөрийг нь эмсэлж болдсон байх жишээтэй. Би баазад I курсээс эхлэн гурван жил дараалан ажиллаж байна. Зунхаа амралтаараа ажиллаад сургалтын төлбөрөөс чөлөөлөгдөнө гэдэгт ховорхон тохихоо аз завшаан.

-Сургалтын төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөгдөж оюутнуудад их хэрэгтэй зүйл?

-Тийм шүү. Зун ажилласан оюутнуудын сургалтын төлбөрийг зохих хувиар хасдаг. Би эхний жилдээ 30 хувиар төлбөрөө хөнгөлүүлж байсан. Дараагийн жил нь 100 мянган төгрөг буюу гурван кредит. Өнөө жил сургалтын төлбөрийг маань 100 хувь хөнгөлсөнд маш их баяртай байгаа.

-Амралтаараа баазад ажилласнаар эдийн засгийн ач холбогдлоос гадна хэл сурахад хэр үр дүнтэй вэ?

-Япон хэл үзэж байгаа оюутнуудын хувьд жуулчны баазад өөр тутаи жуулчидтай харилцаж байгаа нь хэлний мэдлэгийн түвшингээ дээшлүүлэхэд маш дөхөм болдог. Тавилтай хүн талын чинээ гэдэгчлэн гадна дотнын олон сайн найз нөхөдтэй боллоо.



Олон улсын сэтгүүлчийн 3с ангийн оюутан Б.Бат-Эрдэмтэй уулзж ярилцлаа.

Анх ажиллаж байхдаа шангарч байсан үе бий. Тэгээд гэдэг хойш суухыг бодсонгүй. Одоо эргээд өөрийн гараар хийж бүтээгээ харуулах бахархалтай санагддаг.

-Анх бааз нээгдэх цагаас эхлэн ажилласан гэсэн үг үү?

-Тийм. Намайг анх очиход жуулчны бааз гүйцэд баригдаагүй байсан. Барилгын ажил 70 хувьтай явж байсан.

-Япон хүмүүс Монголын юуг илүүтэй их сонирхож байна?

-Монголын хөх тэнгэр их сайхан юм. Од харъя гэгцээдэг. Морь унах бас их сонирхолтой. Ялангуяа "Хармони центр" группээс жил болгон морь унахаар жуулчид ирдэг. Өнөө жил "Бютек" хэмээх Японы компаниас 50 хүнтэй долоон групп ирлээ.

-Оюутан залуусын дунд хөгжилтэй явдал их тохиолдоно биз. Нэгээхэн хэсгээс хуваалцахгүй юу?

-Оюутнууд бүгд жагсаж зогсож байгаад жуулчдад өөрсдийгөө танилцуулдаг дүрситэй. Тэгтэл I курсийн нэг оюутан өөрийгөө танилцуулах гэж байгаад "Миний нэрийг хэн гэдэг вэ?" гэж буруу хэлээд бөөн инээдэм болж байсан. Манай баазад жил болгон ирдэг жуулчид ч бий. Бид их дотно танил найз болдогдог.

-Захиагаар их харилцана биз. Олон найзтай болж байна уу?

-Олон найз нөхөдтэй болсон. Захиа болон мейтээр байнга харьцаж хоёр улсын сонин сайхнаасаа хуваалцана. Тэднээс сурах, авах олон юм бий. Цагийг яс барьдаг. Нэг удаа оройн хоолон дээр нэгэн жуулчин надад саваахуу хоол өгсөн юм. Би санаанд ч оролгүй нөгөөдөхийг нь саваахуу авчигдсан. Саваанаас сава руу дамжуулдаггүй өс заншилтай юм билээ. Нэг бол таваг тавьж өгнө. Эсвэл шууд амаа өгөх ёстой.

-Бусад сургуулиас давуу тал аль хэр олон бэ?

-Багшлах хүчин гэдэг маш чухал. Арав шахам япон багш нарыг урьж авчраад бидэнд ихээхэн заалгана гэдэг үнэхээр бахархмаар. Япон багш нар ихээхэн заахдаа маш сайн. Дүнгээ тавихдаа ямар ч "найраа" байхгүй. Хан юу мэдэж байна түүгээр нь үнэлнэ. Энэ нь нэг талаас оюутнуудыг хариуцлагатай болгож ихээхэн улам мөрийлтэй болгох "шахалт" болдог.

-Төгсөгчдөө гадаад руу суралцуулах болон ажлын шуугаар явуулдаг. Чиний хувьд төгсөөд цаашдаа ямар бодол зорилготой байна?

-Миний хувьд зорилтоо тодорхойлохсон гэж хэлж болно. Одоо хондро нууц. Ирсэн гийгн биддэг гэдэг шиг насан туршдаа сурина гэж юу байхав. Одоо төгсөх гэж байна. Энэ сургуулиараа насан туршдаа оонолгож явах болохоор сургуультайгаа хойшид байнга холбоотой байна. Аюулгүй байхад нь эхлээд их сургууль болтол нь удирдаж яваа Соёлт багшдаа нийт оюутнуудад өмнөөс баярлалаа гэдгээ хэлжээ. Өнөөгийн манай улсын нөхцөлд жил болгон 30, 40-өөр нь Япон руу төгсөгчдөө явуулдаг сургууль

ТӨГСӨГЧ ЯРЬЖ БАЙНА

Хэлтэй бол
далавчтай

"МОНЦАМЭ" агентлагийн "Монгогу Цүшин" сониний япон хэлний редактор Т.Наранмандахтай хэдхэн хором ярилцсанаа толилуулж байна.

-Соёл-Эрдэм дээд сургуульд хэдэн онд элссэн бэ?

-2000 онд элсэн орж шалгалт өгөөд 1-р курсээ алгасаад шууд 2-р курсээ орж байсан. 3-р курс суралцаж байхдаа япон хэлний мэргэжил дээшлүүлэх шалгалтанд тэнцэж Япон явсан.

-Та урьд нь япон хэл сурч байсан уу. Хэл сурахад анх аль хэр хүндрэл бэрхшээлтэй байв?

-Би багваасаа хэл сурах сонирхолтой байсан л даа. Ингээд гадаад хэлний 38-р дунд сургуулийг төгссөн. Төгсөөд Япон руу гурван сарын курст суралцаад "Соёл Эрдэм" дээд сургуульд элсэн орсон.

-Оюутан насныхаа хөгжилтэй, дурсамжтай мичүүдээс дурсвал?

-Манайх их дүрсгүй хөгжилтэй анги байсан! Бун-Кэо "Сайд оролцохоор өдөр шөнөгүй бэлдэж байсан тэр мөч санаанд тод үлдсэн. Бас бид "Б" байрны 15 номерийн ангид өөрсдөө засвар хийж байсан. Хүүхдүүд өөрсдөө

хийсэн зүйлдээ их хайртай болдог юм билээ. Засвар хийснээсээ хойш өрдөө ч хөг тарьдаггүй байсан.

-Хүндэлж явдаг багш нараасаа дурсаач?

-Намайг сурч байхад Оноо, Урата гэдэг япон багш нар байсан. Тэд тун сайн багш. Мөн монгол багш нараас Г.Алим багш байна.

-Япон хэл сурснаар таны амьдралд гарсан өөрчлөлт юу вэ. Энэ сургуулийг төгсөөрөө бахархах үе гарч байсан уу?

-Би япон хэлийг 5-р ангиаас эхлэн үзсэнээсээ хойш одоог хүртэл энэ сурсан мэдсэнээрээ амьдралаа залуулж явна даа. Хүссэн сайхан амьдралаараа амьдрахад минь япон хэл тулгуур болж өгдөгт баяртай байдаг.

-Манайд японоор гардаг сонин бараг үгүй. Та хэдэн жилийн өмнөөс эхлэн энд ажиллаж эхэлсэн бэ?

"Монгогу Цүшин" сонин 2003 оны аравдугаар сараас албан ёсоор гарч эхэлсэн. Манай сонин Япон улс дахь Монголын Элчин сайдын яам болон Монголд үйл ажиллагаа эрхэлж буй япон компани, иргэдэд курч чаддаг. Үүний зэрэгцээ энэ хэлийг их олон хүн сонирхон суралцаж болсон болохоор уншигчдын тоо нэмэгдэх хандлагатай байгаа. Миний төгссөн сургууль бол Монголд япон хэлний чиглэлээр сургалт явуулдаг хамгийн сайн сургууль. Одоо япон хэлний орчуулагч багшаас гадна зургаан мэргэжлийн чиглэлээр оюутан бэлдэж байгаа нь сайшаалтай хэрэг. Ийм сайн сургуульд сурч буй оюутан залуус та бүхэнд сайн сураарай, эх орно хөгжилтэй гарч байна шүү. Хэлтэй бол далавчтай гэж хэлжээ дээ.

Олон улсын сэтгүүлчийн 3с ангийн оюутан Т.Отгонсүрэн



Сургуулийн харьяа "Шилийн бүлэг" жуулчны бааз

ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ



Ерөнхийлөгч Н.Энхбаярын хамт. 2006.8 сар



Зүүн гар талаас "Соёл Эрдэм" дээд сургуулийн гүйцэтгэх захирал П.Дорж, Чүбү Когаё Бютия группийн гүйцэтгэх захирал Ямашиита, тус группийн ерөнхийлөгч Фукуда Козо, Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Соёл Эрдэм дээд сургуулийн ерөнхий захирал Макихара Соичи. Жич - Фукуда Козо нь 2006 оны 6-р сард Монгол Улсын Японы Насая дахь өргөмжлөлт консулаар томилогдсон.



АНУ-д суугаа Ренбүүчи ача гэзээн хамба лам Монголд илчлэл хийх үеэр, 2006.8 сар



Тайшо их сургуульд цаагйн багш, доктор Эрдэнэбаатарын хамт. 2006. 8 сар



Японд суралцаж буй оюутнууд хаврын баярын уулзалтаар. 2006. 5 сар



Аварга Ж.Мөнхбатын хамт. 2006. 7 сар



Японы алдартай кино жүжигчиний хамт. 2006. 7 сар

ИХ МОНГОЛ 800 ЖИЛИЙН ОЙН 500 МОРЬТОН БААТРУУДЫН ҮЗҮҮЛБЭР ТОГЛОЛТЫН ҮЕЭР АЖИЛЛАСАН ОЮУТАН



амарч чадсан оюутнуудаас та бүхэнд танилцуулж байна.

Сургуулийнхаа томилолтоор ажил хийж 450 ДОЛЛАРЫН ЦАЛИН АВСАН

Зуны амралт, чөлөөт цагаараа ажил хийж мөнгө олж нь оюутнуудын хувьд хамгийн чухал зүйл байдаг. "Соёл эрдэм" дээд сургуулийн нэгэн давуу тал бол зуны амралтаараа сургуулийнхаа жуулчны бааз болон бусад газруудад ажиллахад зуучилж өгдөг. Өнгөрсөн зуны амралтаараа төлбөрөө бэлдэж ашигтай

-Тааерийгөө танилцуулахгүй юу? -Намайг Отгонсүрэн гэдэг. "Соёл эрдэм" дээд сургуулийн 3-р курсын оюутан. -Зуны амралтаа яаж өнгөрүүлсэн бэ? -Төв аймгийн Сэргэлэн суманд Япон улсын хөрөнгө оруулалтаар гурван жилийн хугацаатайгаар гэрээ байгуулсан "Чингис хаан 800 жилийн дараа эргэж

ирсэн нь" 500 морьтон баатруудын үзүүлбэр тоглолтон дээр ажилласан. -Ямар чиглэлээр ажил хийе? -2000 хүний суудалтай дөрвөн асар байдаг. 500 морьтон баатрын үзүүлбэр, урлагийн тоглолтон томоохон цогцолбор байгуулагдсан. Манайд өдөр 400-800 хүн нэг дор ирдэг байсан. Хамгийн их хүнтэй өдөр нь долдугаар сарын 9-н буюу нээлтийн өдөр 1600 орчим хүн цугласан. Би зочдыг угтан авах, машины зогсоол дээр машин зохицуулах, зочдын аюулгүй байдлыг хангах зэрэг хамгаалалт зохион

байгуулагчийн ажил хийж байсан. -Сургуулиас хэдэн оюутан ажилласан бэ? -17 оюутан авна гэсэн боловч 21 оюутан шалгалтанд тэнцэж явсан. -Ямар шалгалт авсан бэ? -Япон хэлний ярианы чадварын шалгалт болон зохион бичлэгийн шалгалтыг авсан. -Ажил хийх хугацаандаа сургалтын төлбөрөө бэлдэж чадсан гэж дуулсан юм байна? -Тиймээ. Сард 200\$ буюу хоёр сарын хугацаанд 400 \$ Үүн

дээр шагналын 50\$-ын цалин авсан. -Ажил хийх хугацаанд гарсан дэвшил юу вэ? -Япон хэлний ярианы чадвар нэлээд дээшилсэн. Сургалтын төлбөрөө төлж чадсандаа баяртай байгаа. -Оюутнуудаа хандаж хэлэх үг юу байна? -Япон хэл болон бусад хичээлүүдэд цаг тухайд нь хийж хичээх юм бол ямар ч зүн амжилтад хүрнэ гэж боддог. Олон улсын сэтгүүлчийн 3с ангийн оюутан Т.Бэрэлчимэг

パンフレット

私はバトエルデネと申します。私の家は首都ウランバートルから240キロ離れたダラハンという町にあります。モンゴル文化教育大学のジャーナリスト学科学生です。モンゴル文化教育大学には9人の日本人の先生がいます。私は遊牧民出身ですのて、趣味は乗馬です。夏休みには、大学の近くに馬場があります。



たしの名前はヨーンです。ウランバートルに家族は3人、二人の弟がいます。本日は大学のパンフレットの制作をやっています。また、日本から来た乗馬クラブに参加した乗馬初体験をしたお話を聞きました。日本語はもう上手です。私も乗馬が好きです。お話を聞きました。私はアリオンゾルと申します。ウランバートルのモンゴル文化教育大学環境観光学科学生です。今年20歳になります。1人家族です。趣味は乗馬、その次はダンス、カラオケかな。毎年大学のキャンプ地ではウエトレスをやっています。今年もウエトレスをやりました。来年も冷たいビール、美味しいワインを持って日本からのお客さんを持ってまいります。



たしの名前はラと申します。モンゴル文化教育大学日本語科です。今年、大学の草創期に入学し、乗馬インストラクターとして実習しています。グランドに地ついたら、一生忘れられない場所です。それは林田(林田千鶴子様)ご夫妻の日本のお父さんご家族に会ったことです。私は両方なく、卒業が近づくと好きな大学に続けるのが困難になってしまいました。それを察知した林田ご夫妻様が、わたしのことを心配してくださり、卒業するまでの学費を一括払いで全部学校に払ってくれました。卒業するまでの生活に学校を通して毎月40,000トグル(1,000円)を受け取っております。それ以外に手術のための3万円いただきました。林田ご夫妻のご好意のおかげで、家族で成りました。なにかを言ったら、いかに分かりません。としても思慮して、日本の皆様がいかに素晴らしいか、インストラクターとして頑張ります。私も家族も日本人好きです。日本の皆さん！本当にありがとうございます。

タヌキは化けて人をだます!?

タヌキは古くから、おそらく数十年前から、日本列島に住み着いていた原始的なイタ科動物である。タヌキは、最近では郊外の住宅地などに現れ、人間と交流する姿がニュースになることも、日本人にとって、タヌキは身近な野生動物の一つなのだ。だがタヌキが身近なのは、今に始まった事ではない。大昔からずっと、なのである。それは、タヌキの好みの生活場所が、海岸べりから丘陵地帯、低山帯までの森だったからだ。彼はそこでミミズなどの小動物を食べていた。そして、何万年も前の事であろうが、同じような環境を好む人間が移住してきて、両者は出会ったのだ。以

知られているものに大入道(坊主頭の大男)がある。古寺などで脱もじやの大道が化けて人をだますというものだ。古い寺や荒れ果てたお堂の床下に棲みついたタヌキは、夜にネズミなどの獲物を求めて活動、時には建物の中を走り回ったりしたのである。大きな建物にたつた一人、留守番を言いつつ小僧が、タヌキの物音におびえながらも見回って責任を果たそうとしたとき、暗い本堂などを覗くと、いつも見る阿彌陀如来像や釈迦像が大入道に見えたことが想像できる。また、月明かりの晩に、酒徳利と通帳を携えた小僧に化けて、よく人をたぶらかしたと



来、タヌキと人間は深く関わり合ってきた。その中からタヌキが登場する民話なども生まれたのである。日本の民話や伝説に出て来るタヌキは、よく化けて人をだます。これは古代の中国から伝わった伝説の影響を受けていると言われている。中国の伝説では、さまざまな動物が妖怪となり、数々の怪異現象を引き起こす。中世になると、このような妖怪の話が変化して、タヌキは動物の妖怪を代表するものとなり、老婆を喰い殺してその姿に化け、数知れぬほどの人々を喰った。などという残酷な話もできた。「老婆」話は、雑食性のタヌキが、動物の死骸などを掘り起こして食べるところから発展したのだろう。こうして民話や妖怪話の背景には、いずれも動物の習性があったことはいうまでもない。民話などで、タヌキがよく姿を変えることで

に顔の辺りをいじられて目が覚め、びくっり仰天と云う次第なのだろう。人なれしたタヌキは、人間が横たわっていると食べ物でもないかと近寄って、何があるのか確かめるつもりで匂いを嗅ぎ回す。人間は、説明できない不思議な事柄や、恥をかけた体験などの原因を動物のせいにしてきたのである。時代によって、タヌキに対する人間の接し方は大きく変わってきた。だがタヌキの方はずっとタヌキのままである。多くの野生動物が棲息数を減らした今、タヌキは貴重な動物とされている。日本人にとって、(身近にいて当たり前の)動物、それがタヌキなのだが、これからもそうであり続けて欲しいものである。

歌で学ぶ日本語

歌: ヒット・ソング -ラブ・ストーリー- は突然に 歌: 小田和正
① 何から伝えればいいのか わからないまま時は流れて 浮かんでは消えてゆく ありふれた言葉だけ
② 君があんまり素敵だから ただ素直に好きと言えないで たぶんもうすぐ雨もやんで、二人たそがれ
③ 誰かが甘く誘う言葉に もう心揺れたりしないで 切ないけど そんな風に心は縛れない
Цаглашгүй хайраа чамдаа хэльеу гээсэр Цаг хугацаа нэгэн хэмээр урсан одлоо Хэлэхээр завдсан үгээ цааш нь залгиад Хэвшиж тогтсон энгийн үгээр чамтай хүүрнэнэ
Чя минь дэндүү сайхан төрсөн болохоор Чяи зүрхийн үгээ шууд хэлж зүрхлэхгүй Удахгүй ингэддэ бороо зогсоно Уйтгар гунгийн баран сүүдэр замхарна
Тэр өлөр тэр цагт тэр нэгэн газар Таарч чамтай учраагүйсэн бол Бид хоёр хэзээг ч хүртэл Бие биесээ мэлэхгүй л байсан болов уу
突然 ときが流れる 伝える 素直 素敵 僕ら 見知らぬ 誘う 心揺れる 切ない
とつぜん ときながれる つたえる すなお すてき ほくら みしらぬ あまい さそう ころころゆるる せつない
Хэн нэгний налуун үгэнд Хоёрдож сэтгэл минь урвахгүй ч Амраг хайрын сэтгэлд нь болбол Аргамжиж зүрхээ тогтоошгүй нь
Маргаашийн өдрийг болоход Магад чамайг би улам ихээр хайрлана Энэ бүх бодлыг зүрхэндээ тээсээр Эгнэгт цаг хугацааг туулан одно
Алив бүхнээс чамайг хамгаалах Даль жигүүр минь байх Аядуу зөөлнөөр чамайг илбэх Тэр салхин болоо
гэнэт цаг хугацаа урсах дамжуулах байгаагаараа илэн далангүй гайхалтай сайхан бид таньж мэлэхгүй нхлуун, хуурамч урих, уриалах сэтгэл хоёрдох шаналантай, харуусмаар



ЗАЛУУСЫН БУЛАН

Энэхүү буландаа оюутан залуусын өөрсдийн туурвисан уран бүтээлээс толилуулж байна.

Хайрын мессеж

Хаврын анхны бороотой хамт чиний анхны мессеж ирж билээ. Энгийн товч үгтэй хэрнээ сэтгэлд нэг л дулаахан мессежийг чинь уншаад л баймаар. Гэнц нэгхэн дуслах борооны түрүүцээс чийг үнэртээд л Тиймээ гэр өдрийн бороо тэгэхэд ирсэн мессеж яг л өчигдөр мэт санагдаж байна. Нэг л мэдэхэд намар болчихож Хаврын шувуудтай хамт ирэхдээ чи анхны хайрын үрийг зүрхэнд минь суулгасанаа мэдээ ч үгүй намрын шувуудтай буцаад явчихсан Чамайг хүлээгээ юу. Бороог хүлээгээ юу сэтгэл гунигаа даахгүй дайвалзана. Шөнө бүр зүүдэндээ нартай бороо зуныг зүүдэлж өглөө бүр сэрэхдээ чамайг үгүйлнэ. Би чиний тухай ахиад л

бодлоо хөглөн зогсоном. Чи бид хоёр хамтдаа зөвлөн шиврээ бороо, аянга цахилгаантай ширүүн аадар хичнээн ч үзэв дээ Гэхдээ чамайг надад өвчирсэн шиг куртай өдөр ахиад тохирсонгүй. Гадаа ахиад л бороо орж байна. Магадгүй энэ жилийн сүүлчийн хур ч юм билүү. Цонх тогшин урсах бороон дуслууд миний бодлыг таах гэж уралдах мэт. Бодлод дарагдсаар нэг мэдэхэд унтчихаж. Өглөө сэрэхэд уулын толгойд цас унаад салхи нь хүртэл сэтгэл сэмлэн сэргэгэнхийг яна.

Дахиад л ай хөөрхий гээд санаа алдмаар Гэнэт утас дуугарлаа. Түүнээс мессеж ирж байна. Тиймээ ахиад хэзээ ч явахгүй бүр мөсөн ирж байна.

НУУЦХАН ХАЙР

Чамайг санхь тоолонд

Гунигийн салхи үлээж

Чангахан нэрийг чинь шивнэх төдийд

Гунигийн бороо асгардаг.

өртөөлөн одох он жилийн уртад

өөр хэнийг ч биш чамайг үгүйлэхдээ

вр зурх минь цөхрөө чинээ санасангүй

Бороотой үдэш болзоо бүхнээ мартаад

Бодлын энгээр шавласан дурсамж бүхнээ гээгээд

Аниргүйхэн мэлтийх түгэ түмэн одоос

Алдрайхан чамайг асууна чинээ бодсонгүй

Хэлж амжаагүй сэтгэлийн үгээ

Хээнцэр иэцэгсийн дэлбэнд задля

Дурсамж бүхнээс ургах дүрийг чинь

Дундуур сэтгэлдээ үүрр хадгалъя.

Олон улсын сэтгүүлчийн Зс ангийн оюутан А.Ням-Өлзий

Шинэ оюутнуудаа угтах танилцах үдэшлэг



Анхны үдэшлэг. Анхны харц. Анхны халуун дотно яриа. Тийм ээ үйл явдлаар өрнөл тэмүүлээр дүүрэн танилцах үдэшлэг энэ сарын 16-нд "Хамелон" диско клубт болж өнгөрлөө. Үдшийн зургаан цагаас арван цаг хүртэл үргэлжлэх ч багахан хугацаагаар хэтрэв. Нэгдүгээр ангийнхан ангиараа мандчилгаз дэвшүүлж өөрсдийнхөө авьяасыг олонд

"илчлэв". Багш, оюутнуудын дунд өрнөх сонирхолтой тэмцээн уралдаанаар дүүрэн үдэшлэг хэн бүхний сэтгэлд хоногшсон үлгэж чадсан болов уу. Залуу насны эрч хүч дүүрэн золбоолог залуус. Хэзээ ч мартагдашгүй бидний үдэш, үдэшлэг.

Олон улсын сэтгүүлчийн Зс ангийн оюутан З.Билэгжаргал

Хаана суралцаж болох вэ?

Япон улсын Кокушिकан их сургууль,
Япон улсын Хэкухо их сургуулийн хоёр жилийн сургалттай охидын коллеж,
Япон улсын Сэйжөө их сургууль,
Япон улсын Такушөөкү их сургуультай багш оюутан солилцооны хөтөлбөр,
Япон улсын "Бютек" групп. Төгсөгчдийг 1-3 жилийн хугацаатай мэргэжил дээшлүүлэх төслийг хэрэгжүүлдэг,
Тайванийн Кайнан их сургууль,
Дээрх сургуулиудад оюутнууд хичээлдээ онц мэрийлттэй сурч шалгалтын босгыг давж чадав үнэ төлбөргүй болон хөнгөлттэй суралцах бүрэн боломжтой.

Телевизийг 3 цагаас хэтэртэл үзвэл амархан өвчинд нэрвэгдэж болзошгүй

1.ЭСЭРГЭНЭ:

Телевизийн экранд үлэмж хэмжээний тогтуун цахилгааны цэнэг байдаг. Энэхүү төвлөрсөн цэнэг нь гэрэл тоосоор дамжаад хүний нүүр царайнд хүрдэг, ийм байдалд нүүр царайгаа нэн даруй аятай сайхан угтаж цэвэрлэхгүй юм бол нүүр царай дээр чинь арилгаж цэвэрлэхэд бэрхтэй оог цоог толбонууд буюу эсэргэнэ гарч болзошгүй юм.

2.ТЕЛЕВИЗИЙН НӨЛӨӨНӨӨС БОЛСОН ГАНЦААРДМАЛ ӨВЧИН:

3-7 насны хүүхдүүд урт хугацаагаар зурагт үзвэл алсдаа тун ганцаардмал мөртлөө хүмүүстээ үл нийлэх маш сонин зантай болдог юм байна. Энэ бол нэг зүйлийн сэтгэл зүйн өвчин эмгэг юм.

3.ХАНИАД ХҮРЭХ:

Телевизорын дэргэд удаан хугацаагаар суухад гэрийн гадна хийх ажил цөөрч, нарны гуяанд зэгдэх хэмжээ багасч, шинэ сайхан агаар амьсгалах нь багасч, булчин махбодийн дархлаа буурдаг учраас тун амархан ханиад хүрдэг байна.

4.ТАРГАЛАХ ӨВЧИН:

Телевиз сонирхоход бие цогцын хөдөлгөөн багасч, арьсны дор өөх хурж байдаг, телевиз үзэхдээ бас цэнэги ихтэй аар саар хүнсний зүйл идэх нь ч хүмүүсийг санаандгүй байдалд таргалуулдаг байна.

5.НҮД ХАТАХ ӨВЧИН:

Зурагтын дэлгэцний өөдөөс хараад удаан цагаар суухад нүдний цэцгийд цус хурж, нүдний цэцгийн харааны мэдрэх чадавхыг алдагдуулахын зэрэгцээ нүдний цэцгийг хуурай болгодог байна. Ингээд хүнд ноцтой нөлөө гарах юм бол харааг муудуулж, мэдрэлийг замбараагүй болгодог байна.

6.ГЭДЭС ХОДООДНЫ ӨВЧИН:

Телевиз үзэхийн дагуу хоол идэх нь ходоодонд муугаар нөлөөлдөг. Бүртгэлээс үзвэл, телевизийг нэг дор 3 цагаас илүү үзсэн хүмүүсийн 40%-иас дээшх нь бүгд ходоод унжих өвчин болон ходоодны шархлаа зэрэг өвчин эмгэгт нэрвэгдсэн байна.

7.ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧИНД НЭРВЭГДЭХ:

Аймшгийн буюу сэдэлт ихтэй телевизийн кино үзсэний дараа цусны даралт нэмэгдэх юм уу зүрхний өвчин хөдлөх зэрэг илрэл гардаг байна. Телевизийг 3 цагаас хэтэртэл үзэх юм уу, маш удаан цагаар сонирхож суух нь энэхүү 7 зүйлийн өвчинд амархан нэрвэгдэж болзошгүй бөгөөд хүний бие махбодийн эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг талтай болохоор телевиз үзэх цагаа аятай сайхан тохируулах нь зүйтэй юм.

Бэлтгэсэн Олон улсын сэтгүүлч З.С.А.Бужинлхам

Хэрэв та сонингийн цаас шагайхаас залхсан бол

Техник технологийн үнэ цэнийг ойлгодог болсон өнөө үед бид сонингийн цаас шагайж хайран цагаа үрэх хэрэггүй боллоо. Учир нь гэвэл та гэртээ, ажил дээрээ, хаана л интернет байна тэнд сонин унших боломжтой. Хэрэв та интернетээс сонин хэвлэл уншихаар шийдсэн бол www.soinin.com хаягаар орж доорх хэвлэлүүдээс сонгон авч унших боломжтой.

Өдөр тутмын сонин:

-Өдрийн сонин
-Өнөөдөр сонин
-Ардын эрх

Долоо хоног тутмын сонин:

Бэлтгэсэн Олон улсын сэтгүүлчийн Зс ангийн оюутан Ч.Гүнсмаа

-Даяар Монгол
-Бизнес таймс
-Бизнес мэдээ
-Зиндаа
-Инфо
-Монголын нэг өдөр
-Соёмбо
-Тэргүүн
-Улс төрийн сонин
-Хүмүүс
-Хүмүүсийн амьдрал
-Арав хоног тутмын сонин
-Маш нууц
-Монголчуудын амьдрал
-81-р суваг
-Бөх
-Дээдсийн амьдрал
-Ноцтой мэдээ
-Утга зохиол
-Сэрүүлэг
-Хань зэрэг хэвлэлүүдээс хэрэгцээтэй мэдээллээ унших боломжтой.

“Соёл Эрдэм” дээд сургуулийн япон багш нарын танилцуулга

Байгаль цаг уурын эрс тэрс уур амьсгалтай Монгол орныг зорин ирж оюутан залуус бидэнд эрдэм ном, япон хэл сургаж буй сайхан сэтгэлт багш нартаа талархлаа илэрхийлье.



Куросава Кимико

Японы охидын их сургуулийн уран зохиол-англи хэлний чиглэлээр суралцаж төгссөн. Казэу охидын ахлах сургуульд багшилж байсан. “Соёл Эрдэм” дээд сургуульд 10 дахь жилдээ багшилж байгаа туршлагтай багш.



Ешида Такэши

Хуулийн Сэншюү дээд сургуулийн хуулийн ангийг төгссөн. Саппоро хотын тамгын газарт ажиллаж байсан. IAY интернейшнл академийг төгссөн.



Оошима Мари

Токиогийн хөдөө аж ахуйн дээд сургуулийн нэгдүгээр ахлах сургууль төгссөн. Биеийн тамирын Кокушикан их сургууль төгссөн.



Канетака Такэши

Токио хот, Шинжүүү ахлах Хаянната дээд сургуулийн уран зохиолын ангийг төгссөн. Эдогава дүүрэг, хөдөлмөрийн байгууллага, Токио хот, Сэида дүүрэг байгаль орчны нөхөн сэргээлтийн хэсэгт ажиллаж байсан.



Токухиса Масаюки

“Соёл Эрдэм” дээд сургуулийн Япон хэлний тэнхимийн эрхлэгч. Хуулийн Чююо сургууль төгссөн. Токио хотын хөдөлмөрийн байгууллагад ажиллаж байсан.



Танака Масанори

Шизуока муж, Готэнба ахлах сургууль. Биеийн тамирын Кокушикан их сургууль төгссөн.



Кобаяши Тоёми

Хоккайдо мужийн хөдөө аж ахуйн дээд сургуулийг төгссөн.



Канетака Такако

Мэисэи дээд сургуульд сэтгэл судлал, боловсролын талаар суралцсан. Канагава муж, Кавасаки хотын Коорицу бага сургуульд багшилж байсан.

Сэйжёо их сургуулийн танилцуулга

Япон улсын Сэйжёо их сургуульд суралцахаар 12 оюутан эх орноосоо мөрдлөө.

Анх 2005 оны арванхоёрдугаар сарын 9-ний өдөр Сэйжёо их сургуульд элсэгчдийн анхны элсэлтийн шалгалт Монголд болж байсан.

Олон залуус шалгалт өгсөн боловч “Соёл эрдэм” дээд сургуулийн оюутнуудаас өөр тэнцсэн хүн гараагүй гэдгийг дуулаад тайхаж магад.

“Соёл эрдэм” дээд сургуулийн сургалтын чанар өндөр. Японд очиж суралцахад хэлний бэрхшээл тулгарахгүй байх хэмжээнд хүрч чадахуйц сургалтаа явуулдаг учраас ийнхүү бусад их дээд сургуулиас ялгагдахуйц өндөр үнэлгээтэй байгаа ажээ. Монголын икэн их дээд сургууль зуныхаа амралтаар амарч өнгөрүүлдэг бол тус сургуулиас оюутнуудаа хөтөч-тайлбарлагчийн ажил олж өгч хэлний мэдлэгийг нь дээшлүүлэхэд анхаардаг. Японд дээд сургуулиа төгсөөд ажилд орохын өмнө оюутнууд нь дадлага хийх буюу ажилд орох шалгалтыг өгдөг. Мөн төгсөх үед нь ажилд орох газар нь нэгэнт тодорхой болсон байх нь олонтой.

Манайд улсын хувьд ажлын байр тэр болгон олдоогүй. Сургуулиа төгсөөд ажил шууд орох боломж багатай байдаг.

“Соёл эрдэм” сургууль нь өөрийн сургуулийн төгсөгч на-



Сэйжёо их сургуулийн багш нар Японд суралцаж байгаа оюутнуудын хэсэг хэлд танилцуулга хийж байгаа нь.

рынхаа цаашдын ирээдүйг дэмжих үүднээс Сэйжёо их сургууль, Хакуо охидын коллеж зэрэг сургуультай харилцаа холбоо тогтоож оюутнуудаа суралцуулж байна.

Хэлийг зөвхөн дээд сургуулийн дөрвөн жилд үзээд зогсохгүй цаашид үргэлжлүүлэн суралцах буюу япон хэлтэй холбоотой ажил эрхэлнэ гэдэг ховор боломж.

Анх 2004 онд Сэйжёо их сургуулийн элсэлтийн шалгалтын танилцуулга болж, улмаар амьжиргааны зардлын тухайд Чибү компани өөрийн компанийн зүгээс ажлын байраар хангаж дэмжлэг үзүүлэхээр болсон билээ. Энэхүү системийн давуу тал нь “Соёл-Эрдэм” дээд сургуулийн шилдэг оюутнуудыг сонгон

шалгаруулж Сэйжёо их сургуульд 4 жилийн зуугацаанд Эдийн засгийн чиглэлээр мэргэжил эзэмшүүлж, ирээдүйн чиг замаа тодорхойлоход нь тус болох юм. Ийнхүү оюутнууд маань

Азийн бусад орны оюутнуудтай дотно нөхөрлөн, Япон төдийгүй бусад олон улс орны соёлоос суралцах өргөн боломж нээгдэж байгаа юм.

Сэйжёо их сургууль нь “Соёл эрдэм” дээд сургуультай хамтарсан гэрээний дагуу оюутнуудыг 70 хувийн хөнгөлөлттэйгөөр суралцуулдаг. Өнгөрсөн жилээс эхэлсэн бөгөөд 12 оюутан амжилттай суралцаж байна. Японы Чүбү Когёо Бютек групп нь тэнд сурч буй оюутнуудад орон сууц болон ажлын байраар хангаж суралцахад нь дэмжлэг ихэд үзүүлж байгаа аж.

Мөн бүх оюутнуудыг Notebook-ээр хангасан. Энэ нь монгол оюутнуудад сурах нөхцөлийг бүрдүүлж өгч байгаа вадал. Энэ дашрамд Чүбү Когёо Бютек группын ерөнхийлөгч Фукуда Козо болон хамт олонд нь талархаж байгаагаа илэрхийлэе.

Хичээлийн шинэ байр барихад хандив өргөв



“Фукияма” барилгын компанийн захирал Фукияма 500.000 иен хандивлав.

Токио хотын Хийн компанийн Монголд айлчилж ирсэн хамт олон 1.000.000 иен хандивлав.

“Соёл-Эрдэм дээд” сургуулийн шинээр баригдаж буй барилганд Япон улсын компани, хувь хүний хандив төдийгүй тус сургуулийн төгсөгч нар 4 сая гаруй төгрөгийг бэлэглэсэн юм. Оюуны их өргөвд мөнгөн тусламж үзүүлж буй бүх хандивлагчдадаа баярлаж талархсанаа илэрхийлэе.

Сургалтын төлбөр өссөөр байх уу?

Оюутан бидний хувьд сургалтын төлбөрөө төлөх нь хамгийн явцгай асуудал. Сургалтын төлбөр орон даяар нэмэгдэж байгаа. Энэ талаар Сургалт хариуцсан захирал Ч.Чимэдсүрэн ийнхүү ярьж байна.

“Жил бүрийн сургалтын төлбөрийн хэмжээг бусад сургуулиудын сургалтын төлбөрийн жишиг хэмжээ болон өрхийн орлогын түвшинтэй уялдуулан тогтоодог. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн утгаараа цалингийн түвшний өсөлт инфляцийн түвшинтэй уялдуулдаг гэсэн үг. Хэдийгээр манай сургууль сургалтын чанараараа дээгүүр байр эзэлдэг ч энэ жилийн хувьд бусад их дээд сургуультай харьцуулбал харьцангуй бага хэмжээтэй төлбөртөйд орно. Цаашид аль болох өмнө жилүүдийнхтэй жишиг байлгахыг хичээж болно.

“Соёл эрдэм” дээд сургуулийн багш дэлхийн хэмжээний докторын зэрэг авлаа

“Соёл эрдэм” дээд сургуулийн профессор, багш Г.Аким дэлхийн соёл урлагийн академийн утга зохиолын докторын зэргийг Дэлхийн яруу найрагчдын 26-р их хурлын үеэр гардан авлаа. Түүний орчуулгын болон бичсэн бүх зохиол бүтээл, Монголын утга зохиолд оруулсан хувь нэмрийг нь үнэлж энэхүү нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай цолыг олгосон байна. Ерөнхийлөгч Н.Энхбаяр, яруу найрагч Т.Урианхай, “Соёл эрдэм” дээд сургуулийн профессор Г.Аким нар дэлхийн хэмжээний докторууд боллоо. Манай улсад уг шагналыг анх яруу найрагч, зохиолч Г.Мэнд-Овоо авч байсан бөгөөд ийнхүү нэг дор гурван доктор нэмэгдэж байгаа нь үнэхээрийн бахархууштай явдал юм.

Олон улсын сэтгүүлчийн Эс ангийн оюутан Т.Гэрэлчимэг

"ЗӨВ ЯВБАЛ ЗӨӨЛӨН ЗӨӨЛӨН ЗАМБУУЛИН"

"Соёл-Эрдэм" дээд сургуулийн дэргэдэх "Монгол Эгшиглэн" хамтлагийн дуучин СТА Э.Оюумаа япон хэл сурахдаа сэтгэл шулууджээ.



-Та дөнгөж 15 настайдаа СУИС-д орсон юм уу?

-Тиймээ. Анх шалгалт өгөхдөө тэнцэхгүй ч байж магад гэж өөртөө итгэлтэй байгаагүй. Тэгсэн ч сургуульдаа тэнцсэн. Ингээд 2002 онд СУИС-ийг уртын дуучны мэргэжлээр төгссөн. Оюутан нас хэзээ ч мартгадгүй дурсамжтай үе.

-Та "Соёл-Эрдэм" дээд сургуультай яаж холбогдов?

-Би оюутан байхдаа "Сарны Чулуу" дуу бүжгийн чуулга, мөн "Соёл-Эрдэм" дээд сургуулийн дэргэдэх "Монгол Эгшиглэн" хамтлагт дуучнаар ажиллаж байсан. Энэ хамтлагт найман жил дуулж байна.

-Та хамтлагийнхантайгаа Япон руу олон удаа явсан уу. Ер нь тэнд очоод ямар сэтгэгдэл төрж байв?

-Есөн удаа Японд очсон. Өндөр хөгжилтэй үнэхээр сайхан орон. Тэнд очиход монгол

оюутнуудтай их таарсан. Ихэнх нь "Соёл-Эрдэм" дээд сургуулийн оюутнууд байсан нь энэ сургуулийн сургалт ямар болохыг харуулж байгаа болов уу.

-СТА дуучин Бат-Эрдэнэ та хоёрыг "Соёл-Эрдэм"-д орохоор бүртгүүлсэн гэж сонссон. Энэ үнэн үү?

-Тиймээ, япон хэлний дамжаанд бүртгүүлсэн. Гэхдээ энэ жил цаг зав муутай арай л

амжихгүй байна, ирэх жилээс суралцана даа.

-Та тоглолтоор Япон явж байсан. Япон хэлээр сайн ярьдаг уу?

-Тийм ч сайн биш ээ. Бага зэрэг мэднэ.

-Дуучин Бат-Эрдэнэ та хоёрыг хүмүүс суух гэж байгаа. Сайхан хосууд гэх мэтээр их ярьдаг. Энэ үнэн үү?

-Бат-Эрдэнэ бид хоёр чинь нэг ангийн сайн найзууд. Үргэлж жаргал зовлонгоо хуваалцаж явдаг. Бат-Эрдэнэ надтай учир-санаараа, би Бат-Эрдэнэтэй хамтарч дуулснаараа бид амжилтад хүрч чадсан нь азтай явдал. Бид хоёр ангийнхаа анхны СТА-нууд болсондоо бахархдаг. Түүнээс гэр бүлийн дотнын харьцаа байхгүй ээ.

-Ангийнхан гэснээс оюутан ахуй цагийн дурсамжаас хуваалцаац?

-Манай ангийнхан дунд авьяаслаг, чадарлаг, уран бүтээлч олон бий. Жишээ нь: "Классик Жем"-ийн Уянга, дуучин Мөнхбат. Мөн залуу дуучин Мөнхзул. Тэр сайхан Буриадын гавьяат дуучин болсон. Ер нь бүгд л сайн яваа. Оюутан байхад хөгжилтэй юм зөндөө тохиолдож

байсан. Оюутан нас хэзээ ч мартгадгүй.

-Таны хэлэх дуртай үг?

-Санаа зөв бол заяа зөв гэж боддог. Хүн үнэхээр л зөв санаатай сайхан сэтгэлтэй байхад бүх юм цаанаасаа бүтдэг. Зөв явбал зөвлөн зөвлөн замбуулин гэдэг үгийг сүүлийн үед их хэлэх дуртай болоод байгаа.

-Сүүлийн үед ямар уран бүтээл дээр ажиллаж байна?

-Бат-Эрдэнэ бид хоёр хослон дуулсан дуучдаас хамгийн олон дуэт дуулсан. Хамгийн сүүлд "Хайр" нэртэй 14 дуутай CD гаргасан. Цаашдаа ч хамтарч дуулсаар байх болно.

-"Соёл-Эрдэм" сургуулийн талаархи таны бодол?

-Япон хэлний чиглэлээр өндөр түвшинд боловсон хүчин бэлтгэж гаргадаг. Улсын сургуулиас оюутнууд "Соёл-Эрдэм" дээд сургууль руу их шилжиж ирдэг. Япон улсын Элчингийн тэтгэлэгт шалгалтад тэнцэгдийн ихэнх нь энэ сургуулийнх байдаг. Ер нь сайн сургууль гэж боддог. Захирал Магичара Сойчийн хувь нэмэр их бий. Сойчи бэлтгэл бол сургалтын өндөр чанарыг зорилго болгон ажилладаг хөдөлмөрч хүн.

-Оюутан залуустаа хандаж юу хэлэх вэ?

-Өнөөгийн залуус би зөвлөлдөө их анхаардаг болжээ. Энэ нь маш сайн хэрэг. Хүн ямар ч мэргэжил эзэмшиж болно. Гэхдээ хамгийн чухал нь ямар ч зүйлийг сэтгэлзэсээ хийдэг, чин сэтгэлзэсээ ханддаг байх хэрэгтэй. Дуучин хүн сайн уран бүтээл туурвихын тулд цаг мөч алдалгүй хөдөлмөрлөдөг. Тэгж байж үзэгч, сонсогчийн хүндэтгэлийг хүлээнэ. Барилгачин ч ялгаагүй. Нэг ширхэг тоосгыг ч муруй сарий баш цэгцтэй тавьж навал бат бэх байх вэ олон талаас нь бодолцож хийх хэрэгтэй. Тэгж байж хүн бүхэн монголынхоо төлөө ихийг хийж бүтээнэ. Оюутан залуустаа мэргэжилдээ эзэн нь болж эх орныхоо төлөө ихийг хийж бүтээгээрэй гэж хэлэе дээ.

-Ярилцлага өгсөн таньд баярлалаа. Цаашдын чинь уран бүтээлд амжилт хүсье.

-Баярлалаа.

Олон улсын сэтгүүлчийн
Зс ангийн оюутан
Т.Отгонсүрэн

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛТ

"Соёл-Эрдэм" дээд сургуулийн 2006-2007 оны хичээлийн шинэ жилийн зорилт

"Соёл эрдэм" дээд сургууль нь хичээлийн жилдээ дараах зорилт тавин ажиллахыг чухалчилж байна. Энэ талаар сургуулийн гүйцэтгэх захирал П.Доржоос тодрууллаа.

1. Удирдлагын арга барилыг өөрчлөх, нэгж тэнхим, оюутны зөвлөлтэй хамтран ажиллах ажлыг эрх сайжруулахад онцлон анхаарах.
2. Оюутны зөвлөлийн ажлыг шинэ шатанд гаргах жил болгох.
3. Сургалтын агуулгыг боловсронгуй болгон шинэчлэх, бүх шатанд ажлын чанарыг эрхэмлэх.
4. Сургалтын төлбөр түүний зарцуулалтад хяналт тавих, зүй зохистой зарцуулах түүний эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд анхааран ажиллах, сургалтын таатай орчин бүрдүүлэхэд хамтын хүч анхаарлыг хандуулах.

-Хичээлийн шинэ жилдээ дөрвөн үндсэн том зорилт дэвшүүлжээ. Энэ талаар дэлгэрэнгүй ойлголт өгөхгүй юу?

-2006-2007 оны хичээлийн жилд хамгийн том биелүүлэх даалгавар бол хичээлийн шинэ байр баруулах явдал. Барилгын ажил аль хэдийн эхэлсэн. Арванхоёрдугаар сарын дундуур шинэ хичээлийн байрандаа орно гэсэн тооцоотой байгаа. Түүнээс гадна шинэ хичээлийн жилд дөрвөн үндсэн зорилт дэвшүүлж байгаа. Нэгдүгээрт тус сургуулийн удирдлагын арга барилыг өөрчлөх гэж байгаа. Нэгж тэнхимийн эрхлэгч, оюутны зөвлөлийн дарга гээд удирдах ажилтан бүр өөрийн ажлыг маш тодорхой болгож ажилла. Үүний дараа бүх ажлыг зохион байгуулдаг удирдлагын арга менежментийг сайжруулах жил болгож гэж үзэж байгаа. Хоёрдугаарт оюутны зөвлөлөө шинэчлэх юм. Оюутныг оюутантай нь ажиллуулж, бие даасан үйл ажиллагааг хөгжүүлэхэд бүх анхаарлаа хандуулах гэж байгаа. Дараачийн асуудал бол энэ хичээлийн жилээс эхлэн Аялал жуулчлалын болон Программ хангамжийн, Математикийн бусад төрлийн хичээлүүдийн агуулгыг өөрчилж Одоо тэнхим бүр тусгай даалгавар аваад ажиллаж байна. Сэтгүүл зүйн тэнхимд шинэчлэлт өөрчлөлтийг хийж байгаа. Сэтгүүлчийн ангийг аль болох дадлагажуулах, бичүүлж сургах ярилцлага авах нөхцөл бололцоогоор хангана. Ийнхүү сургалтын агуулгыг өөрчилж байгаа. Дараачийн нэг зүйл бол оюутнуудаас авч буй сургалтын төл-

бөрийн зарцуулалт, хэрэгжүүлэлтэд хяналт тавих, эдийн засгийн үр ашгийг нь нэмэгдүүлэхэд анхаарч байгаа. Эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх замаар сурах орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх үндсэн дөрвөн зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

-Нийт хичээлэн оюутантай сургалтаа явуулж байгаа вэ. Танай сургууль магистрийн сургалт явуулдаг болно гэсэн нь үнэн үү?

-Энэ хичээлийн жилд оюутны болон багш нарын тоо нэмэгдлээ. Жилд 420-оод оюутантай байдаг байлаа. Бид аль болох энэ хэмжээндээ байа. Оюутны тооны хойносо хөөцөлдөх биш чанараа барьж гэдэг бодлоготой яаж ирсэн. Энэ хичээлийн жилд шинэ байр ашиглалтад орохтой холбогдуулаад 520 гаруй оюутантай болж байна. Өөрөөр хэлбэл энэ жил зуу гаруйгаар нэмэгдсэн гэсэн үг. БСШУ-ны яамнаас бидний ажлыг дэмжиж манай сургуулийн сургалтын чанарыг бусад сургуультай харьцуулж үзээд энэ хичээлийн жилд 200 оюутан элсүүлж ав гэдэг зөвшөөрөл олгосон. Үүнийг боловсролын төв байгууллагаас бидэнд үзүүлж байгаа анхаарал дэмжлэг гэж үзэж байна. Түүнээс ашиг хайж тоогоо автоматаар нэмсэн явдал байхгүй. Харамсалтай нь манай сургуульд элсэх хүсэлтэй олон хүүхэд хоцорлоо. Сониндоо дамжуулан хэлээд үлдсэн хүүхдүүдээс хүлцэл өгчөө. Манай сургууль магистрийн сургалт явуулах зорилт тавьж байгаа. Эхний ээлжинд шинэ байртай болж орчноо сайжруулчихаад дараа нь хийгээр төлөвлөсөн ажлууд олон бий.

Япон бүжгийн парад



Сувбатрын гавлбид бүжиглэн байгаа нь.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан "Соёл эрдэм" дээд сургууль, Кумамото мужийн Япон, Монголын найрамдалын нийгэмлэгээс хамтран Япон бүжгийн парадыг өнгөрсөн зун Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Японы үндэсний бүжгийн соёлыг Монголын ард түмэнд танилцуулах зорилгоор "Үшибука Хая", "Үтэмун Соудори" бүжгийг Японы алдартай жүжигчин, бизнесмен, багш гээд төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс оролцон бүжиглэж үзүүлэв. "Соёл эрдэм" дээд сургуулийн 400 гаруй оюутан нийт багш ажилчид оролцоо. Ийнхүү Японы соёлыг Монголд таниулан түгээж хоёр улсын найрамдалт харилцааг хөгжүүлэхэд чухал арга хэмжээ болов. Үндэсний хувцастай бүжиглэгч олныг хүмүүс хараад ихэд шоохоорхон анхаарч зарим нь бүр дагаж бүжиглэж эхэлсэн. "Соёл эрдэм" дээд сургуулийн оюутнаас гадна МУИС, ШУТИС, МУБИС зэрэг бусад их дээд сургуулийн оюутнууд энэ баярын парадд нэгдсэн.



Тус сургууль дээр бүжгийн парадын дахиад үзэж байгаа нь.